



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 1/99

Улаанбаатар хот

**Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн
балансаас хөрөнгө шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 130,497,088.0 /нэг зуун гучин сая дөрвөн зуун ерэн долоон мянга наян найман/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны “Эрүүл-Өрх” өрхийн эрүүл мэндийн төв, 5 дугаар хорооны “Хасагт-Эрдэнэ” өрхийн эрүүл мэндийн төв, 14 дүгээр хорооны “Евро-Эм” өрхийн эрүүл мэндийн төвийн балансад тус тус шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв /Ж.Энхзул/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Баянзүрх дүүргийн “Эрүүл-Өрх” өрхийн эрүүл мэндийн төв /М.Алтанхуяг/, “Хасагт-Эрдэнэ” өрхийн эрүүл мэндийн төв /Г.Цогзолмаа/, “Евро-Эм” өрхийн эрүүл мэндийн төв /Ж.Нарантуяа/-д тус тус үүрэг болгосугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв /Ж.Энхзул/-т, Баянзүрх дүүргийн 4, 5, 14 дүгээр хорооны өрхийн эрүүл мэндийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115550200257

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 04 өдрийн 1/99 тоот тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв

Д/д	Эд хөрөнгийн нэр	Марк үзүүлэлт	Ашиглалтад орсон он	Хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Шилжүүлэн авах байгууллага
машин тоног төхөөрөмж										
1	Зөөврийн эхо аппарат	chison Q8	2016.05.26	ш	1	68,216,888.0	68,216,888.0	39,082,591.90	29,134,296.10	БЗД-ын 5-р хорооны "Хасагт-Эрдэнэ" өрхийн эрүүл мэндийн төв
2	Эхо аппарат /суурин/	Alpion Ecule-7	2009.09.30	ш	1	24,280,200.0	24,280,200.0	24,280,200.00	-	БЗД-ын 4-р хорооны "Эрүүл өрх" өрхийн эрүүл мэндийн төв
3	Эхо аппарат /суурин/	medison X6	2010.12.29	ш	1	38,000,000.0	38,000,000.0	38,000,000.00	-	БЗД-ын 14-р хорооны "Евро эм" өрхийн эрүүл мэндийн төв
Машин тоног төхөөрөмжийн дүн					3		130,497,088.0		29,134,296.10	
Нийт шилжүүлэх хөрөнгийн дүн								130,497,088.0	29,134,296.10	